



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН 2021 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН
ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор
Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 51-261628 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn
Ахлах аудитор: Л.Мөнхцацрал
Утас: 51-261740 Цахим хаяг: munkhtsatsrall@audit.gov.mn
Аудитор: Ц.Мөнхтуяа
Утас: 51-261740 Цахим хаяг: munkhtuyats@audit.gov.mn

Улаанбаатар хот
2022 он

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
Аудит хийсэн ЗГ-ын бондын эргэн төлөлтийн төлөвлөгөө, гүйцэтгэл	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл	10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
4. Аудитын илрүүлэлт	15
4.1 Залруулсан алдаа	15
4.3 Албан шаардлага	15
4.4 Зөвлөмж.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АХГ	Аудитын хоёрдугаар газар
НА	Нийцлийн аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сан
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2022.03.25 № 07/698
танай _____-ны № _____-т

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДАРГА
Я.ЭРДЭНЭСАЙХАН ТАНАА

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар залруулагдаагүй 127,634.8 сая төгрөгийн зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.5, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.4, 13.7, Нийцсэн бөгөөд зохистой байх, Эрх ба үүрэг, Тохиолдсон байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ



Я.САРАНСҮХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	273,657,495,653.74	255,573,795,783.22
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.01	0.01
31100	Кассанд байгаа бэлэн мөнгө	0.01	0.01
31110	Төгрөг	0.01	0.01
33	АВЛАГА	273,657,495,653.73	254,978,361,783.21
33300	Татаас, санхүүжилтийн авлага	40,570,924.11	-
33500	Бусад авлага	52,590,891.00	130,128,301.21
33510	Байгууллагаас авах авлага	48,142,304.00	126,858,714.21
33520	Хувь хүмүүсээс авах авлага	4,448,587.00	3,269,587.00
33600	Зээлийн авлага	273,564,333,838.62	254,848,233,482.00
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	273,564,333,838.62	254,848,233,482.00
33615	Хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид олгосон зээл	273,564,333,838.62	254,848,233,482.00
35	БАРАА МАТЕРИАЛ	-	595,434,000.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	595,434,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	273,657,495,653.74	255,573,795,783.22
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	45,158,721,901.96	16,981,044,439.45
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	66,806,137.46	970,887,511.09
41300	Өглөг	7,444,666.00	817,444,666.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5,750,000.00	5,750,000.00
41360	Бусад өглөг	1,694,666.00	811,694,666.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,694,666.00	811,694,666.00
41400	Урьдчилж орсон орлого	59,361,471.46	153,442,845.09
41440	Бусад урьдчилж орсон орлого	59,361,471.46	153,442,845.09
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	45,091,915,764.50	16,010,156,928.36
42100	Урт хугацаат үнэт цаас	43,646,666,264.50	14,564,907,428.36
42110	Төгрөг	43,646,666,264.50	14,564,907,428.36
42111	Бонд	43,646,666,264.50	14,564,907,428.36
42200	Урт хугацаат зээл	1,445,249,500.00	1,445,249,500.00
42210	Төгрөг	1,445,249,500.00	1,445,249,500.00
42217	Санхүүгийн бусад байгууллага	1,445,249,500.00	1,445,249,500.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	228,498,773,751.78	238,592,751,343.77
51	Засгийн газрын хувь оролцоо	228,498,773,751.78	238,592,751,343.77
51200	Хуримтлагдсан үр дүн	228,498,773,751.78	238,592,751,343.77
51210	Өмнөх үеийн үр дүн	223,881,815,603.84	228,498,773,751.78
51220	Тайлант үеийн үр дүн	4,616,958,147.94	10,093,977,591.99
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	273,657,495,653.74	255,573,795,783.22

2.2 Аудит хийсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,723,352,108.68	11,505,403,501.12
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,723,352,108.68	11,505,403,501.12
120	Нийтлэг татварын бус орлого	8,723,352,108.68	11,505,403,501.12
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	8,154,852,108.68	10,820,610,501.12
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,923,054,063.38	2,884,233,138.37
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	361,913,055.69	294,017,004.07
1200046	Зээлийн хүүгийн орлого	2,869,884,989.61	7,642,360,358.68
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	568,500,000.00	684,793,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,813,666,632.91	1,395,725,909.13
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,813,666,632.91	1,395,725,909.13
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,190,830,592.28	1,395,725,909.13
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	364,862,469.22	27,892,024.11
210101	Үндсэн цалин	252,370,078.03	27,892,024.11
210102	Нэмэгдэл	56,876,948.52	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,295,502.67	-
210104	Урамшуулал	19,319,940.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,455,807.71	-
210201	Тэтгэврийн даатгал	38,379,142.42	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,326,900.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,861,800.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	465,200.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,422,765.29	-
2104	Хангамж, бараа материалын зардал	24,107,597.33	-
210401	Бичиг хэрэг	9,436,820.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,173,590.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,250,469.33	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	246,718.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,769,088.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	205,300.00	-
210604	Урсгал засвар	1,563,788.00	-
2107	Томилолт, зочны зардал	59,880,066.00	-
210702	Дотоод албан томилолт	59,880,066.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	200,158,128.50	12,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	133,934,428.50	12,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,350,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	441,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	60,432,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	492,597,435.52	1,355,533,885.02
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	383,893,750.00	1,355,533,885.02
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	108,703,685.52	-
211	ХҮҮ	415,167,373.91	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	415,167,373.91	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	415,167,373.91	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	207,668,666.72	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,668,666.72	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	207,668,666.72	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	6,909,685,475.77	10,109,677,591.99
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,292,727,327.83	15,700,000.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	936,252,268.83	-
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	1,356,475,059.00	15,700,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	4,616,958,147.94	10,093,977,591.99

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,596,924,523.84	11,357,587.23	243,261,884,069.86	244,870,166,180.93
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(1,596,924,523.84)	-	(19,380,068,466.02)	(20,976,992,989.86)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	11,357,587.23	223,881,815,603.84	223,893,173,191.07
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	(11,357,587.23)	-	(11,357,587.23)
Тайлант үеийн үр дүн	-	-	4,616,958,147.94	4,616,958,147.94
2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	228,498,773,751.78	228,498,773,751.78
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	228,498,773,751.78	228,498,773,751.78
Тайлант үеийн үр дүн	-	-	10,093,977,591.99	10,093,977,591.99
2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	-	-	238,592,751,343.77	238,592,751,343.77

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	35,553,022,509.03	32,183,161,440.67
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,248,469,931.03	32,142,969,416.56
120	Нийтлэг татварын бус орлого	35,248,469,931.03	32,142,969,416.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,248,469,931.03	32,142,969,416.56
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,248,469,931.03	32,142,969,416.56
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	304,552,578.00	40,192,024.11
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	304,552,578.00	40,192,024.11
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	304,552,578.00	40,192,024.11
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,342,751,844.42	2,973,161,440.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,342,751,844.42	2,973,161,440.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,228,859,971.88	2,291,402,604.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	361,221,662.22	27,892,024.11
210101	Үндсэн цалин	248,631,626.00	27,892,024.11
210102	Нэмэгдэл	56,974,593.55	-
210103	Унаа хоолны хөнгөлөлт	36,295,502.67	-
210104	Урамшуулал	19,319,940.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	47,455,807.71	-
210201	Тэтгэврийн даатгал	38,379,142.42	-
210202	Тэтгэмжийн даатгал	2,326,900.00	-
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,861,800.00	-
210204	Ажилгүйдлийн даатгал	465,200.00	-
210205	Эрүүл мэндийн даатгал	4,422,765.29	-
2104	Хангамж, бараа материалын зардал	26,465,528.86	-
210401	Бичиг хэрэг	10,163,320.00	-
210402	Тээвэр, шатахуун	5,173,590.00	-
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	10,194,000.86	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	934,618.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,994,979.00	-
210601	Багаж, техник, хэрэгсэл	28,431,191.00	-
210604	Урсгал засвар	1,563,788.00	-
2107	Томилолт, зочны зардал	59,935,066.00	-
210702	Дотоод албан томилолт	59,935,066.00	-
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	319,837,228.09	12,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	139,533,528.09	12,300,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,350,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	441,200.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	174,512,500.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	383,949,700.00	2,251,210,580.42
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	383,949,700.00	2,251,210,580.42
211	ХҮҮ	415,167,373.91	-
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	415,167,373.91	-
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	415,167,373.91	-
212	ТАТААС	3,867,183,948.70	-
2121	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,867,183,948.70	-
212101	Төрийн өмчит байгууллагад олгох татаас	3,867,183,948.70	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	831,540,549.93	681,758,836.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	207,668,674.74	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	207,668,674.74	-

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	623,871,875.19	681,758,836.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	378,900.00	-
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	40,192,024.11	-
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	583,300,951.08	681,758,836.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	29,210,270,664.61	29,210,000,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	192,117,002.00	-
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	192,117,002.00	-
2200	Дотоод эх үүсвэрээр	192,117,002.00	-
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	192,117,002.00	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(192,117,002.00)	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(29,018,153,670.63)	(29,210,000,000.00)
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	22,816,441,400.00	810,000,000.00
230001	Эргэж төлөгдөх зээл	22,816,441,400.00	810,000,000.00
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	6,201,712,270.63	28,400,000,000.00
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр	6,201,712,270.63	28,400,000,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(8.02)	-
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8.03	0.01
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.01	0.01

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,120,000,000.00	810,000,000.00	(20,310,000,000.00)	3.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	21,120,000,000.00	810,000,000.00	(20,310,000,000.00)	3.8
230001	Эргэж төлөгдөх зээл	21,120,000,000.00	810,000,000.00	(20,310,000,000.00)	3.8
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,120,000,000.00	1,491,758,836.14	(19,628,241,163.86)	7.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,120,000,000.00	1,491,758,836.14	(19,628,241,163.86)	7.1
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,120,000,000.00	1,491,758,836.14	(19,628,241,163.86)	7.1
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.01	0.01	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.01	0.01	

Аудит хийсэн ЗГ-ЫН БОНДЫН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ГҮЙЦЭТГЭЛ

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
230001	Эргэж төлөгдөх зээл	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
37	БУСАД ЭХ ҮҮСВЭР	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
370001	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(41,431,679,000.00)	(29,081,758,836.14)	(12,349,920,163.86)	70.2
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		40,192,024.11
21	УРСГАЛ ЗАРДАЛ		40,192,024.11
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		40,192,024.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		27,892,024.11
210101	Үндсэн цалин		27,892,024.11
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		12,300,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		12,300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		40,192,024.11
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		40,192,024.11
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		40,192,024.11

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитаар шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн гүйлгээ, дансны үлдэгдлийг эрсдэлд суурилж, түүвэрчлэн шалгаж баталгаажуулсан нь АДБОУС-ын дагуу материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад авлага цуглуулалт, зээлийн эргэн төлөлтийг эрчимжүүлэх, бүртгэлийн программын тооцооны зөрүүг арилгах, төсвийг бодитой төлөвлөж, хэрэгжүүлэх, төсвийг хэмнэлттэй зарцуулж, үр ашгийг нэмэгдүүлж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 3 дугаар сарын 8-ны өдрөөс 2022 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн хооронд Үндэсний аудитын газрын ахлах аудитор Л.Мөнхцацрал, аудитор Ц.Мөнхтуяа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер С.Нацагдорж, Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын Орлогч Я.Сарансүх нар тус тус хэрэгжүүлсэн.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 1/0294 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Засгийн газрын 2020 оны 50 дугаар тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, бүтэц, орон тооны хязгаарыг баталсан байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан нь жижиг, дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг дэмжих зориулалттай байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг дараах арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжих зориулалтаар хөнгөлөлттэй зээл олгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид бүтээгдэхүүнээ экспортод гаргасан бол зээлийн хүүгийн татаас олгох;
- Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд бизнес, инкубацийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах, сургалт, давтан сургалтад хамруулах;
- Жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр судалгаа, шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид зориулсан үндэсний болон олон улсын хэмжээний үзэсгэлэн, худалдаа, чуулга уулзалт зохион байгуулах, дэмжлэг үзүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан жижиг, дунд үйлдвэрийг дэмжихэд чиглэсэн тоног төхөөрөмжийн санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;
- Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үндсэн болон өр барагдуулахтай холбогдсон үйл ажиллагаа, үндсэн хөрөнгөтэй холбогдсон зардлыг санхүүжүүлэх.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт зарим талаар сайжирсан хэдий ч, хэрэгжилт үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай.

Тус сангийн санхүүгийн үйл ажиллагаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2019 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн А/385 дугаар тушаалаар баталсан салбарын төсөвт байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас явцын болон гүйцэтгэлийн дотоод хяналтыг дараах чиглэлээр хэрэгжүүлж, ажилласан байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, шилэн дансны тайлангийн тоон мэдээллийг холбогдох маягтад үнэн зөв бөглөөгүй, тайлагнаж ирүүлсэн мэдээлэл нь shilendans.gov.mn сайтын мэдээллээс зөрүүтэй дутагдлуудыг арилгуулж, үнэн зөв тайлагнах талаар мэргэжил, арга зүйгээр хангасан;
- Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж, 4 албан шаардлагын биелэлтийг хангуулах чиглэлээр хяналт тавьж, биелэлтийг нэгтгэн Үндэсний аудитын газарт хүргүүлсэн;
- Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд улирал бүр хяналт тавьж, 2021 оны 3 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор Сайдын 214 тушаалын 236 заалтыг хяналтад авч, хэрэгжилтийг 86.4 хувиар, Төрийн нарийн бичгийн даргын 237 тушаалын 246 заалтыг хяналтад авч биелэлтийн хангуулах чиглэлээр тухай бүр зөвлөмж өгч ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн 2021 оны санхүүгийн тайлан нь ажил, гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагнал гэж үнэлсэн.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу иж бүрэн бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн хувь хэмжээг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 8,723.4 сая төгрөгийн 1.5 хувиар буюу 130.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогын дүнгээс тооцож, 172.6 сая төгрөгөөр тогтоосон.

Материаллаг байдлын суурь үзүүлэлтийн 2021 оны дүн нь төлөвлөлтийн үе буюу-өмнөх оны дүнгээс ихээхэн хэмжээний өөрчлөлтэй байсан тул тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох нь зохистой гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 18.7 сая төгрөгөөр буюу 6.6 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материалын дансдад материаллаг өөрчлөлт гарсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт Б	Эхний үлдэгдэл 1	Эцсийн үлдэгдэл 2	/мянган төгрөг/ Өөрчлөлт 3=2-1
Авлага	273,657,495.7	254,978,361.8	(18,679,133.9)
Бараа материал	-	595,434.0	595,434.0
Нийт хөрөнгө	273,657,495.7	255,573,795.8	(18,083,699.9)
Богино хугацаат өр төлбөр	66,806.1	970,887.5	904,081.4
Урт хугацаат өр төлбөр	45,091,915.8	16,010,156.9	(29,081,758.8)
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	228,498,773.8	238,592,751.3	10,093,977.6
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	273,657,495.7	255,573,795.8	(18,083,699.9)

Авлагын дансны үлдэгдэл 254,978.4 сая төгрөг болж 18,679.1 сая төгрөгөөр буурсан нь Сангийн яамнаас авах татаас санхүүжилтийн 40.6 сая төгрөгийн авлагыг барагдуулж, 18,716.1 сая төгрөгийн үндсэн зээлийн төлбөр, зээлийн хүү, алдангийн авлага эргэн төлөгдөж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжид олгосон зээлийн авлага 77.5 сая төгрөгөөр өссөнтэй холбоотой байна.

Авлагын 42.1 хувь буюу 107,363.7 сая төгрөг нь "муу зээл"-ийн ангилалд байгаагаас жилийн эцэст үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.

Тайлант хугацаанд Хууль, тусгай активын нэгж нь 5,101.0 сая төгрөгийн зээлийг хэвийн ангилалд шилжүүлсэн боловч, дараах "муу зээл"-ийг барагдуулах бодит шаардлага байна. "Муу зээл"-ийн ангилалд байгаа нийт 107,363.7 сая төгрөгийн авлагад шүүхийн нэхэмжлэлийн баримтын бүрдэл хангаж буй 28,588.7 сая, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд яваа 29,284.4 сая, хугацаатай шаардлага тавьсан 24,873.0 сая, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа 10,612.3 сая, шүүхийн ажиллагаатай 11,735.8 сая, эзэн холбогдогч нас барсан 390.6 сая, эрэн сурвалжилж байгаа 681.6 сая, прокурорт шилжүүлсэн 165.1 сая, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 143.2 сая, бусад шалтгаантай 888.9 сая төгрөгийн авлага байна.

Сангаас зээлийн эргэн төлөлтийг сайжруулахаар ажиллахад нэг хуульчид ногдох зээлийн тоо, хэмжээ өндөр, ажлын ачаалал, шүүн таслах ажиллагааны процесс зэргээс хамаарч шийдвэрлэгдэх алхам удаашралтай байдаг нь хүндрэл үүсгэж, цаашид авлага цуглуулалтын зардал өсөх, найдваргүй авлага үүсэх эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 595.4 сая төгрөгөөр өссөн нь Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас ажлын албыг салгаж, Жижиг, дунд үйлдвэрийн газар байгуулсантай холбогдуулж, агентлагийн дансанд бүртгэлтэй байсан 684.8 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг агентлагийн балансаас, сангийн баланс руу шилжүүлэн бүртгэсэн, 73.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг хувь хүмүүс болон аж ахуйн нэгжид зээлээр олгож, ШШГЕГ-ын харьяа 417 дугаар нээлттэй хорих ангийн баланс руу хүмүүжигч нарын жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор 15.7 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй шилжүүлсэнтэй холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 970.9 сая төгрөг болж 904.1 сая төгрөгөөр өссөн нь Зах зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх төслийн санхүүжилт, сонгон шалгаруулалтаар шалгарсан хоршоодод тус сангаар дамжуулан 810.0 сая төгрөгийн зээлийг олгосон болон зээлийн эргэн төлөлтийг урьдчилан шилжүүлсэн, харилцагч тодорхойгүй 94.1 сая төгрөгийн орлогын гүйлгээг урьдчилж орсон орлого дансанд нэмж бүртгэснээс шалтгаалсан байна.

Урт хугацаат өр төлбөрийн данс 16,010.2 сая төгрөг болж 29,081.8 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын бондын өр төлбөрийг барагдуулсантай холбоотой байна. Дансны үлдэгдэлд Сангийн яаманд төлөх бондын 14,564.9 сая төгрөгийн, Өмнөговь аймгийн Засаг даргатай

байгуулсан 190717/01/247 дугаар гурвалсан гэрээний дагуу буцаан төвлөрүүлэх 1,445.3 сая төгрөгийн дамжуулан зээлийн өглөг бүртгэлтэй байна.

Цэвэр хөрөнгө өмчийн дүн 238,592.8 сая төгрөг болж, тайлант оны үр дүн 10,094.0 сая төгрөгөөр өссөн нь нэмж зээл гаргалгүй, сангийн зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үндсэн үйл ажиллагааны орлого өмнөх оноос 2,782.0 сая төгрөгөөр буюу 31.9 хувиар өссөн нь зээлийн эргэн төлөлтөөс төвлөрүүлэх төсөвт байгууллагын өөрийн орлого 2,665.7 сая төгрөгөөр, агентлагийн данснаас 684.8 сая төгрөгийн бараа материалыг балансаас балансад шилжүүлж бүртгэснээр үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өмнөх оноос 116.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Ковид-19 цар тахлын үед Засгийн газраас өгсөн чиглэлийн дагуу харилцагчдын бизнесийн тогтвортой байдлыг хангах, ажлын байрыг хадгалах зорилгоор ХХААХҮС-ын 2020 оны А/373, 2021 оны А/1, А/12, А/42, А/129 дугаар нийт 5 удаагийн тушаалаар, 211 иргэн, аж ахуйн нэгжийн гэрээний зээлийн хүү, алданги төлөлтийн графикт хугацааг 6 сараар хойшлуулан тооцсон байна.

Нийт зардал өмнөх оноос 418.0 сая төгрөгөөр буюу 23.0 хувиар буурсан нь Засгийн газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урсгал үйл ажиллагааны зардлыг агентлагийн балансад салгаж бүртгэсэн, тайлант онд сангаас нэмж зээл гаргаагүйтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны төсвийг “Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх, ажлын байр бий болгох” хөтөлбөрийн хүрээнд 21,120.0 сая төгрөг, Засгийн газрын бондын эргэн төлөлтөд 41,431.7 сая төгрөг, нийт 62,551.7 сая төгрөгийн эх үүсвэрийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлж, 21,120.0 сая төгрөгийн зээл гаргаж, бондын эргэн төлөлтөд 41,431.7 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байна.

ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2021 оны 01/435 дугаар албан бичгээр сангаас санхүүжүүлэх агентлагийн урсгал үйл ажиллагааны зардлын хуваарийг 2,004.8 сая төгрөгөөр баталсан боловч төсөв захирагчаас санал авалгүй төсөвт зохицуулалт хийж, зардлыг бууруулан 1,334.4 сая төгрөгөөр баталсан байна.

Засгийн газрын агентлагийн үйл ажиллагаанд шаардлагатай зардлын эх үүсвэрийг ЖДҮХС-ийн төсвөөс хууль, эрх зүйн актаар санхүүжүүлэх хувь, хэмжээг тогтоолгүйгээр санхүүжүүлж байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасанд нийцэхгүй байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд гүйцэтгэлээр үндсэн үйл ажиллагааны орлогоос 21,120.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 1,491.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, эргэж төлөгдөх зээлд 810.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Оны эцэст улсын төсөвт татан төвлөрүүлсэн 681.8 сая төгрөгийг бондын төлбөрт суутган тооцуулсан байна.

Засгийн газрын бондын эргэн төлөлтөд үндсэн үйл ажиллагаанаас 41,431.7 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж төвлөрүүлэхээс гүйцэтгэлээр 29,081.8 сая төгрөгийг төвлөрүүлсэн нь батлагдсан төсвийг 29.8 хувиар буюу 12,349.9 сая төгрөгөөр дутуу хэрэгжүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого нийтдээ 31,978.1 сая төгрөгөөр тасарсан нь Коронавируст цар тахлын улмаас Засгийн газрын өгсөн үүрэг, чиглэлийн дагуу зээлийн үндсэн төлбөр, алдангийн төлбөрийг удаа дараа зогсоосон нь голлон нөлөөлжээ.

Сангийн төсвийн нийт зардал 810.0 сая төгрөг буюу 3.8 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь төсвийн төлөвлөлтийг хэт өөдрөгөөр тооцоолсон, тайлант оны сангийн орлогын эх үүсвэрийн ихэнх хувийг бондын эргэн төлөлтөд зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Өмнөх онд төвлөрүүлсэн төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 40.2 сая төгрөгийн татаас санхүүжилтийн авлагыг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч, албан хаагчдын урамшуулалд 27.9 сая төгрөг, эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд 12.3 сая төгрөгийг тус тус зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны “Агентлаг байгуулах тухай” 49 дүгээр тогтоолоор Сан болон Жижиг, дунд үйлдвэрийн газар болгон өөрчлөн зохион байгуулж, агентлагийн орон тооны дээд хязгаарыг 39 байхаар баталж, гүйцэтгэлээр 41 албан хаагч ажилласан байна.

Тайлант онд 2 хөтөлбөр, 4 арга хэмжээний хүрээнд 21,120.0 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлийн хэрэгжилт 3.8 хувьтай, Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан 2 зорилтын хүрээнд 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 100.0 хувь хэрэгжүүлснээр тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитаар илэрсэн материаллаг бус алдаа, зөрчилд үндсэн хөрөнгийн үнэлгээ ба бүртгэл, ашиглалт, хамгаалалттай холбоотой эрх, үүргийн нийцэлтэй холбоотой асуудал зонхилж байгаад анхаарч, хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 20 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд Шилэн дансны нэгдсэн цахим системд 26 мэдээлэл байршуулахаас 15 мэдээллийг хугацаанд нь, 11 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Зарим мэдээллийг хугацаа хоцроосон асуудлыг Аудитын нэгдүгээр газрын “Шилэн дансны тухай” хуулийн хэрэгжилтийн аудитын нэгтгэсэн тайлангийн үр дүнд нэгтгүүлэхээр аудитын цахим системд оруулав.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 4 зөвлөмжийг бүрэн биелүүлж, “жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө зээлдэгч нартай тооцоо нийлж баталгаажуулж байх”

албан шаардлагыг шүүх, хяналтын байгууллагаар шалгагдаж байгаа, хуулийн хэлтсийн тусгай ажиллагаа хийж байгаа “муу зээл”-ийн хүрээнд бүрэн хэрэгжүүлэх боломжгүй болсон байна.

Хүснэгт-2 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт
/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	4	158,617.9	3	206.4	1	158,411.5	75
Зөвлөмж	1		1				100
Нийт дүн	5	158,617.9	4	206.4	1	158,411.5	87.5

Жилийн эцэст хэвийн төлөлттэй зээлийн хувьд харилцагч нартай авлагын үлдэгдлийг тулган баталгаажуулсан бол шүүхийн маргаан, шүүхийн шийдвэр гүйцэтгэж байгаа, эрэн сурвалжилж байгаа, эзэн холбогдогч нь нас барсан, хөөн хэлэлцэх хугацаа дууссан зэрэг “муу зээл”-ийн хувьд тулган баталгаажуулалт хийгээгүй тул албан шаардлагын хэрэгжилтийг 50 хувиар үнэлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн зээлийн эргэн төлөлтийн орлогоос 29,081.8 сая төгрөгийн бондын төлбөрийг төсвийн гүйцэтгэлийн тайланд орлого бууруулан тусад нь тайлагнасныг Засгийн газрын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар, бондын төлбөрийг 2022 онд бүрэн барагдуулсан эсэхийг дараагийн аудитаар шалгахаар төлөвлөв.

Мөн ЖДҮХС-ийн төсвөөс Агентлагийн үйл ажиллагааны урсгал зардлыг санхүүжүүлж байгаа нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Агентлагийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байгаа зөрчилд дараагийн аудитаар нийцлийн горим, сорил хэрэгжүүлж, үр дүнг аудитын тайланд тусгах шаардлагатай гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийн хүрээнд нийт 128,636.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 1,001.5 сая төгрөгийн 2 алдааг залруулж, 127,047.8 сая төгрөгийн зөрчлийг арилгах 5 албан шаардлага хүргүүлж, 586.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн 127,634.8 сая төгрөг нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 172.6 сая төгрөгөөс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 1,001.5 сая төгрөгийн дараах алдааг санхүүгийн тайланд тусгаж, залруулга хийлгэн баталгаажуулав. Үүнд:

- Тайлант оны орлогыг дутуу бүртгэснээс, авлагын дансанд 319.7 сая төгрөгийн сөрөг утгатай үлдэгдэл тайлагнасан;
- Төсвийн гүйцэтгэлийн тайланд 681.8 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохируулах бичилт хийлгүй, зардлаар тайлагнасан.

4.3 Албан шаардлага

Аудитаар илэрсэн 127,047.8 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчилд 5 албан шаардлага хүргүүлжээ. Үүнд:

1. Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн авлагын 42.1 хувь буюу 107,363.7 сая төгрөг нь “муу зээл”-ийн ангилалд байгаагаас шүүхэд шилжүүлэх шаардлагатай 28,588.7 сая, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд яваа 29,284.4 сая, хугацаатай шаардлага тавьсан 24,873.0 сая, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа 10,612.3 сая, шүүхийн ажиллагаатай 11,735.8 сая, эзэн холбогдогч нас барсан 390.6 сая, эрэн сурвалжилж байгаа 681.6 сая, прокурорт шилжүүлсэн 165.1 сая, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 143.2 сая, бусад шалтгаантай 889.0 сая төгрөгийн авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5 “хариуцлагатай байх”, Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай

хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16 “Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина”, Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 15 дугаар зүйлийн 15.1 “Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ”, 15.2 “Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монголбанкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: “Муу зээл”-ийн эргэн төлөлтийг сайжруулах, зээлийн гэрээний үүргийн биелэлтийг хангуулах төсвийн шуурхай удирдлагыг хэрэгжүүлж, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

2. Тайлант оны орлогын төлөвлөгөөг бодитой төлөвлөөгүйгээс төсвийн орлого 93 хувь, буюу 19,628.2 сая төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.2.2 “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 14 дүгээр зүйлийн 14.2.2 “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох”, 22 дугаар зүйлийн 22.1 “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана” заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, орлогын төлөвлөгөөг санхүү, төсвийн нөөц, боломжид тулгуурлан бодитой тооцон төлөвлөх, Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлж, батлагдсан төсвийн гүйцэтгэлийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3. Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх ажлын байр олгох хөтөлбөрийн санхүүжилтээс 12.3 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 “төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, тэвчиж болох зардлыг гаргахгүй байх, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

4. ШШГЕГ-ын харьяа хорих 471 дүгээр ангид хүмүүжигчдийн жижиг болон гар үйлдвэрийг дэмжих зорилгоор 15.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг шилжүүлэхдээ эрх бүхий байгууллагын шийдвэр гаргуулаагүй байна.

Энэ нь ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 1.2-т “Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ”, 5.1-д “Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

5. Өмнөх оны төсвийн давсан орлогыг зарцуулах тушаал, шийдвэргүйгээр албан хаагчдад 27.9 сая төгрөгийг урамшуулал олгосон байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмын 4 дүгээр зүйлийн 4.1.4 “Төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж Сангийн сайдын тушаалыг үндэслэн жилд 2 удаа төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах эрх нээн санхүүжүүлнэ”, Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй захиран зарцуулж, тэвчиж болох зардал гаргахгүй байх, Засгийн газрын тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах албан шаардлага хүргүүлээ

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн гүйлгээний анхан шатны баримт бүрдэлтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Анхан шатны баримтын бүрдэл дутуу 84.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтын бүрдүүлэлтэд тавих хяналтыг сайжруулж, орлого, зарлагын аливаа гүйлгээний нотлох баримтыг зохистой түвшинд бүрдүүлэх, баримтын иж бүрдэл хангасан ажил, гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэх;

2. Авлагын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Тоног төхөөрөмжөөр олгосон зээлийн эргэн төлөлт, гэрээний үүргийн хэрэгжилтийг хяналт тавих нэгж тодорхой бус, хүү тооцохгүй шалтгаанаар зээлийн программд бүртгээгүй, дотоод хяналт сул байгаа нь Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16 “Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина” гэж заасантай нийцэхгүй байна.

2.3. Өгсөн зөвлөмж:

Тоног төхөөрөмжөөр олгосон зээлийн эргэн төлөлтийн хяналтыг хэрэгжүүлэх нэгжийг тодорхой болгох, график хуваарийн дагуу төлөлт хийж байгаа эсэхэд хяналт тавьж, зээлийг хэвийн төлөх нөхцөлийг бүрдүүлэх;

3. Зээлийн программтай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Зээлийн бүртгэлийн программын хөгжүүлэлт хийгээгүйгээс үндсэн зээлийн бодит үлдэгдлийг санхүүгийн тайлангийн дүнгээс 493.9 сая төгрөгөөр, зээл төлөлтийг орлогын бүртгэлээс 116.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4 “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө,

эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна” гэж заасантай нийцэхгүй байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Зээлийн эргэн төлөлтийн программ, санхүүгийн тайлан, авлагын дэлгэрэнгүй тайлангийн бүртгэлийн зөрүүг арилгах, сан хариуцсан нягтлан бодогчийн хариуцлагыг сайжруулж, дотоод хяналтын тогтолцоог оновчтой бүрдүүлж, хэрэгжүүлэх;

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагатай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн бүтэц, чиг үүрэгт орсон өөрчлөлтийг дагаж мөрдөхдөө санхүүгийн тайлан, бүртгэлд орох өөрчлөлтийг урьдчилан тооцож, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, чиглэлээр хангаж ажиллаагүйгээс сангийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн оны эхний үлдэгдэлд урсгал үйл ажиллагааны 1-10 сарын орлого, зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлангийн оны эцсийн үлдэгдэлд урсгал үйл ажиллагаатай холбоотой 9.1 сая төгрөгийн авлага, өглөг тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх зааврын 2.1.7 "Санхүүгийн тайлан дахь үзүүлэлтүүдийн толилуулга ба ангиллыг нэг үеэс дараагийн үед тогтвортой хадгална", 2.1.8 "Төсвийн байгууллагын санхүүгийн тайлан нь өмнөх үеийн болон бусад төсвийн байгууллагын санхүүгийн тайлантай зэрэгцүүлэхүйц байвал зохино" гэж заасантай нийцэхгүй байна.

4.2. Өгсөн зөвлөмж:

Сангийн балансас Агентлагийн урсгал үйл ажиллагаатай холбоотой гүйлгээг салган бүртгэх, цаашид бүтцэд гарсан өөрчлөлтэй уялдуулж, нягтлан бодох бүртгэлийн бодлого, зарчимд орох өөрчлөлтийг урьдчилан тогтоож, санхүүгийн удирдлагаар хангаж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

№	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	/мянган төгрөгөөр/							
					Нийт алдаа зөрчил		Залруулга		Албан шаардлага		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Тайлант онд сангаас нэмж зээл гаргалгүй, ЗГ-ын бондын эргэн төлөлтийг гүйцэтгэснээс үндсэн үйл ажиллагааны төсвийн орлого, зарлагын хэрэгжилт 19,628.2 сая төгрөгөөр тасарсан байна.	Орлогыг бодитой төлөвлөх, батлагдсан төсвийн хэрэгжилтийг хангах албан шаардлага	1	19,628,241.2			1	19,628,241.2		
2	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Давсан орлогыг зарцуулах эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр сангийн 2020 оны орлогын зарцуулаагүй үлдэгдлээс 27.9 сая төгрөгийг албан хаагчдад урамшуулал бодож олгосон байна.	Төсвийг хэмнэлттэй зарцуулах албан шаардлага	1	27,892.0			1	27,892.0		
3	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Баримтын бүрдэл дутуу 84.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн	Төсвийг хэмнэлттэй зарцуулах албан шаардлага	1	84,000.0					1	84,000.0
4	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх ажлын байр олгох хөтөлбөрийн санхүүжилтээс 12.3 сая төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд зарцуулсан байна.	Төсвийг хэмнэлттэй зарцуулах албан шаардлага	1	12,300.0			1	12,300.0		
5	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн зээлийн авлагын 42.1 хувь буюу 107,363.7 сая төгрөг нь "муу зээл"-ийн ангилалд байна. Үүнд: Шүүхэд шилжүүлэх шаардлагатай 28,588.7 сая, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд яваа 29,284.4 сая, хугацаатай шаардлага тавьсан 24,873.0 сая, эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байгаа 10,612.3 сая, шүүхийн ажиллагаатай 11,735.8 сая, эзэн холбогдогч нас барсан 390.6 сая, эрэн сурвалжилж байгаа 681.6 сая, прокурорт шилжүүлсэн 165.1 сая, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 143.2 сая, бусад шалтгаантай 889.0 сая төгрөгийн "муу зээл"-ийн авлага байна. Тайлант хугацаанд Хууль, тусгай активын нэгж	Зээлийн эргэн төлөлтийг хангуулж, муу зээлийг бууруулах албан шаардлага	1	107,363,700.0			1	107,363,700.0		

**Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

			нь 5,101.0 сая төгрөгийн зээлийг хэвийн ангилалд шилжүүлсэн байна									
6	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Тоног төхөөрөмжөөр олгосон зээлийн эргэн төлөлт, гэрээний үүргийн хэрэгжилтэд тавих дотоод хяналт сул, хүү тооцдоггүй шалтгаанаар зээлийн программд бүртгэж, хяналт тавиагүй байна.	Зээлийн эргэн төлөлтөд дотоод хяналт хэрэгжүүлэх	1	-					1	-
7	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Зээлийн бүртгэлийн програмын хөгжүүлэлт хийгээгүйгээс үндсэн зээлийн бодит үлдэгдлийг санхүүгийн тайлан /тооцооны үлдэгдэл/-ын дүнгээс 493.9 сая төгрөгөөр, зээлийн төлөлтийг, орлогын бүртгэлээс 116.3 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тайлагнасан байна.	Зээлийн бүртгэлийн програм дахь зөрүүг арилгах	1	493,900.0					1	493,900.0
8	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Хорих ангид хүмүүжигчдийнжижиг үйлдвэрийг дэмжих зорилгоор сангийн балансаас 15.7 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ШШГЕГ-ын балансад үнэ төлбөргүй шилжүүлсэн боловч эрх бүхий байгууллагаас хөрөнгө шилжүүлэх талаар шийдвэр гаргуулаагүй байна.	Алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх	1	15,700.0			1	15,700.0		
9	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн бүтэц, чиг үүрэгт орсон өөрчлөлтийг дагаж мөрдөхдөө санхүүгийн тайлан, бүртгэлд орох өөрчлөлтийг урьдчилан тооцож, нягтлан бодох бүртгэлийн удирдлага, чиглэлээр хангаж ажиллаагүйгээс сангийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайлангийн оны эхний үлдэгдэлд урсгал үйл ажиллагааны 1-10 сарын орлого, зарлагын гүйлгээ, санхүүгийн тайлангийн оны эцсийн үлдэгдэлд урсгал үйл ажиллагаатай холбоотой 5.8 сая төгрөгийн өглөг, 3.3 сая төгрөгийн авлага тайлагнасан байна.	Санхүү, бүртгэлийн удирдлагыг сайжруулах, үйл ажиллагаатай холбоотой зардлыг агентлагийн балансруу шилжүүлэн бүртгэх	1	9,019.6					1	9,019.6
10	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Тайлант оны орлогыг дутуу бүртгэсэнээс, авлагын дансанд 319.7 сая төгрөгийн сөрөг утгатай үлдэгдэл тайлагнасан;	Алдааг залруулах	1	319,700.0	1	319,700.0				
11	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	АХГ-2022/18/НА-СТА-ЗГТС	Төсвийн гүйцэтгэлийн тайланд 681.8 сая төгрөгийн төвлөрүүлэх шилжүүлгийг тохирлуулах бичилт хийлгүй, зардлаар тайлагнасан.	Алдааг залруулах	1	681,800.0	1	681,800.0				
НИЙТ ДҮН					8	128,636,252.8	2	1,001,500.0	5	127,047,833.2	4	586,919.6



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 676/А0160023

Улаанбаатар хот

АХТ-2022/118/НД-СТА-357С

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жижиг дунд үйлдвэрийг дэмжих, хөгжүүлэх ажлын байр олгох хөтөлбөрийн санхүүжилтээс 12,300,000.00 төгрөгийг албан хаагчдын эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2 "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2020 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарч ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дарга Я.Эрдэнэсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэн дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

W:\10.10.20\Bichig_Khureg\Alban Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-311.Docx

0001081657



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 675/А0160073

Улаанбаатар хот

АХГ-2022/18/НӨ-СТА-3ГТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Засгийн газрын бондын эргэн төлөлтийг гүйцэтгэснээс үндсэн үйл ажиллагааны төсвийн орлого, зарлагын хэрэгжилт 19,628,200.00 төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", 6 дугаар зүйлийн 6.2.2 "жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх", 22 дугаар зүйлийн 22.1 "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дарга Я.Эрдэнэсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

С.НАЦАГДОРЖ

Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг-1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban-Shaardlaga\2022\0325 Auditin 2 Gazar-309.Docx

0001091653



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 674/А0160073

Улаанбаатар хот

АХТ-2022/48/НА-СТА-ЗТТС

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хорих ангид хүмүүжигч нарын жижиг үйлдвэрийг дэмжих зорилгоор сангийн балансаас 15,700,000.00 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг ШШГЕГ-ын балансад үнэ төлбөргүй шилжүүлсэн боловч эрх бүхий байгууллагаас хөрөнгө шилжүүлэх талаар шийдвэр гаргуулаагүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 1.2 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эд хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, акталж данснаас хасах, шилжүүлэх саналаа энэ журамд заасны дагуу Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт тавьж шийдвэрлүүлнэ", 5.1 "Эрх бүхий байгууллагын шийдвэрээр болон бусад шаардлагаар төрийн өмчит хуулийн этгээд илүүдэлтэй буюу ашигладаггүй эд хөрөнгийг шилжүүлэх, бусад байгууллагын өмчлөлд байгаа эд хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авахдаа өмч эзэмшигч байгууллагын зөвшөөрлийг авч, холбогдох баримт материалыг энэхүү журамд заасны дагуу бүрдүүлэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт хөрөнгө шилжүүлэх талаар хүсэлт тавьж шийдвэрлүүлэх, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дарга Я.Эрдэнэсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 400 /АО160073

Улаанбаатар хот

АХГ-2022/18/МА-СТА-ЗТТС
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн зээлийн авлагын 42.1 хувь буюу 107,363,700,000.00 төгрөг нь "муу зээл"-ийн ангилалд байна.

Тайлант хугацаанд Хууль, тусгай активын нэгж нь 5,101,000,000.00 төгрөгийн зээлийг хэвийн ангилалд шилжүүлсэн боловч хангалттай үр дүнд хүрээгүй, дараах "муу зээл" хэвээр байна.

Шүүхэд шилжүүлэх шаардлагатай 28,588,700,000.00, шүүхийн шийдвэр гүйцэтгэх шатанд яваа 29,284,400,000.00, хугацаатай шаардлага тавьсан 24,873,000,000.00, эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа 10,612,300,000.00 шүүхийн шатанд 11,735,800,000.00, эзэн холбогдогч нас барсан 390,600,000.00, эрэн сурвалжилж байгаа 681,600,000.00, прокурорт шилжүүлсэн 165,100,000.00, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 143,200,000.00, бусад шалтгаантай 888,969,143.00 төгрөгийн авлага байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3 "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх", Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.16 "Сан нь зээлийн болон дамжуулан зээлдүүлэх гэрээний биелэлтэд хяналт тавина", Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор баталсан "Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 15.1 "Жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага зээлдэгчтэй байгуулсан зээлийн гэрээ, эргэн төлөлтийн хуваарийн дагуу зээлийн эргэн төлөлт, зээлийн хүү, алдангийг тухай бүр төлүүлнэ", 15.2 "Зээлдэгч нь зээлийг гэрээнд заасан хугацааны дотор эргэн төлөх үүргээ биелүүлээгүй тохиолдолд жижиг, дунд үйлдвэрийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь чанаргүй активын ангилалд оруулж, Монгол банкны зээлийн мэдээллийн санд чанаргүй зээлдэгчийн ангилалд бүртгэнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авч ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дарга Я.Эрдэнэсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АХЛАХ АУДИТОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 25

№ 877/А0160073

Улаанбаатар хот

АУГ-2022/118/НД - СТА-3ГТ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр 2020 оны орлогын зарцуулагдаагүй үлдэгдлээс албан хаагчдад 27,900,000.00 төгрөгийн урамшуулал олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" 1.3 "..... цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 4.1.4 Төсвийн санхүүжилтийн асуудал хариуцсан нэгж Сангийн сайдын тушаалыг үндэслэн жилд 2 удаа төлөвлөгөөнөөс давсан орлогыг зарцуулах эрх нээн санхүүжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын 2020 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, зайлшгүй шаардлагатайгаас бусад зардал гаргахгүй байхад анхаарч ажиллах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн дарга Я.Эрдэнэсайхан, Ерөнхий нягтлан бодогч Б.Сэргэлэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТӨРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
С.НАЦАГДОРЖ
Л.МӨНХЦАЦРАЛ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichir_Khereg\Alban_Shaardlaga\2022\0325_Auditin_2_Gazar-310.Docx

9006109
9019120396

0001081655

